



# УЛААНБААТАР

## хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

Улаанбаатар хот

1975 оны 7 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар I-2

*Бүтээх*

ХОТ, РАЙОНЫ АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ САНХҮҮГИЙН ХЯНАН  
БАЙЦААХ ТАСГИЙН ДҮРМИЙГ БАТЛАХ  
Т У Х А Й

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 100 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хянан байцаах тасгийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хянан байцаах тасгийн байцаагчдын хариуцан шалгах байгууллагын хуваарь болон шалгалтын график, ажил үүргийн хуваарийг батлаж, санхүүгийн хяналт шалгалтыг 7-р сарын 15-наас эхлэн шинэ журмаар явуулхыг санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.

3. БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын эмхэтгэл, хөдөлмөр цалин хөлсний улсын хорооны мэдээлэлийг хотын санхүүгийн хянан байцаах тасагт хуваарилан өгч байхыг Зохион зааварлах хэлтэс /н.Шарав/, Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэс /н.Намжил/-д даалгасугай.

4. Районы АДХ-ын гүйцэтгэх захиргаадад даалгах нь:

а/ Районы санхүүгийн хянан байцаах тасгийн байцаагчдын хариуцан шалгах байгууллагын хуваарь, 7 хоногийн шалгалтын

2.

гражикийг батлан өгч 7-р сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдүүлэх.

б/Хяналт шалгалтын графикийг хэрхэн биелүүлд байгаад үргэлжийн хяналт тавьж шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг нэн даруй засаж арилгах арга хэмжээ авч байсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ДАРГА *[Signature]* С.БАЛБАР

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦДАГАГАЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА *[Signature]* Н.ШАМБАЛ

174

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх  
захиргааны 1975 оны ... р тогтоол-  
оор батлав.

УЛААНБААТАР ХОТЫН ХОТ, РАЙОНЫ АДХ-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ САНХҮҮГИЙН ХЯНАН  
БАЙЦААХ ТАСГИЙН ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл.

1. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хянан байцаах тасгийн үйл ажиллагаа нь: Санхүү, бүртгэл тооцооны ажлыг сайжруулах талаар нам, засгаас тавьж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, улсын өмч хөрөнгийг үрэгдүүлэн шамшигдуулах, үр ашиггүй зарцуулах явдлаас урьдчилан сэргийлэх энэ талаар гарч байгаа дутагдлыг цаг тухайд нь илрүүлэн засаж арилгах, рүүнийг дахин давтан гаргуулахгүй байдад чиглэгдэж санхүүгийн хууль, дүрмийг хэрэгжүүлэн биелүүлэхэд оршино.

2. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хянан байцаах тасгаг нь хот, районы төсөвтэй харилцаж байгаа үйлдвэр аж ахуйн газар, төсөвт байгууллагуудын аж ахуй санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж 7 хоногоор зохиосон графикийн дагуу баримтын шалгалт судалгааг хийж байна.

3. Санхүүгийн хянан байцаах тасгаг нь хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтсийн бүтэцэд багтана. Хот, районы санхүүгийн хянан байцаах тасгийн даргын үүрэгт ажлыг хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтсийн дарга гүйцэтгэнэ.

4. Хотын санхүүгийн хянан байцаах тасгаг нь тусгай тэмдэг, районы санхүүгийн хянан байцаах тасгаг нь санхүүгийн хэлтсийн

тэмдэг хэрэглэх ба хоту районы байцаагчид нь өөрийн шалгасан баримтанд дарах хувийн номертой тусгай тэмдэг хэрэглэнэ.

5.Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хянан байцаах тасаг нь хяналт шалгалтын ажлыг жил, улирлаар төлөвлөж/хот нь районуудыг оролцуулан/ хот, районы захиргааны даргаар батлуулаж ажиллахын хамт шалгалтын мэдээ, тайланг тортоосон журмын дагуу гаргаж хотод нэгтгэж сангийн яамны улсын санхүүгийн хянан байцаах газарт явуулна.

Хоёр. Санхүүгийн хянан байцаах тасгийн үүрэг.

6.Хот, районы санхүүгийн хянан байцаах тасаг нь өөртөө шалган байцаах комисстой нам, олон нийт, хоршооллын байгууллагаас бусад үйлдвэр, аж ахуйн ба төсөвт байгууллагуудын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд дор дурьдсан баримтын шалгалт судалгааг хийнэ. Үүнд:

а/Үйлдвэр аж ахуйн байгууллагын үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө нь дотоод нөөц бололцоог дайчлан ашиглах замаар ашиг хуримтлалыг нэмэгдүүлж эдийн засгийн зөв үндэслэлтэй зохиогдсон эсэх, түүнийг биелүүлэх зохион байгуулалтын ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, түүний биелэлт.

б/Үндсэн фондын хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, фонд өгөмжийг нэмэгдүүдэх талаар зохиосон ажлын үр дүн.

в/Материал техникийн хангамжийн байдал, бэлтгэн нийлүүлэгч ба худалдан авагч байгууллагатай хийсэн аж ахуйн гэрээний үүргийн биелэлт, дүгнэлт, эргэлтийн хөрөнгийн ашиглалт, түүний эргэлтийг сайжруулах талаар зохиосон ажил.

в/ Түүхий эд, материал, бүтээгдэхүүн, барааны складын

3.

эмх цэгц, төрөлжилт, эд хөрөнгийн тооллого тооцоо, өр авлагын байдал өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт.

д/Хөдөлмөрийн бүтээмжийн төлөвлөгөөний биелэлт, цалингийн фондын зарцуулалт, орон тооны сахилга бат, тариф, норм, үнэлгээний мөрдөлт.

е/Материал, түүхий эдийн зарцуулалт, орцын нормын биелэлт, материал хэмнэх талаар зохиосон ажил үр дүн.

ё/Эерийн өртөгт ажиллагааны зардлыг хямдруулах ба аривлан хэмнэлт гаргах нэмэгдэл даалгаврын биелэлт

з/Борлуулалт, санхүүгийн үр дүн, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт.

ж/Төсвийг зориулалтаар нь төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэлтэй харьцангуй зарцуулж байгаа эсэх болон батлагдсан төсвөөс хэмнэх даалгаврыг яаж биелүүлсэн, төсөв хэтрүүлэн зарцуулсан шалтгааныг судлаж засах.

и/Анхан шатны ба нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан балансын зохиолт, статистикийн мэдээ материалын үнэн зөв эсэх.

к/Дотоодын хяналт шалгалтын ажлыг удирдагчийн зэрэгцээгээр хяналт шалгалт, хуулийн байгууллагатай хамтран социалист өмчийг хамгаалан бэхжүүлэх, нам засгаас гаргасан хууль, тогтоолын биелэлтийн талаар үзлэг, шалгалт явуулах.

л/Санхүү-аж ахуйн үйл ажиллагааны судалгаа, шалгалтыг албан хариуцлагатны ажлын хариуцлагатай нягт холбон явуулж, илэрсэн ололт дутагдалд дүгнэлт өгөхийн зэрэгцээгээр зөрчил дутагдлыг засах тодорхой санал боловсруулж хэрэгжүүлэх.

м/Санхүүгийн хяналт шалгалтын ба бүртгэл тооцооны ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, тэдний ажлын туршлагыг нийтийн хүртээл болгох ажил зохиох:

н/Санхүүгийн хяналт шалгалтын ажилд туслах зорилгоор хөдөлмөрчдөөс ирүүлсэн мэдээлэлийг анхааралтай судлаж түүний мөрөөр шалгах ба тэрчлэн санал гомдлыг хугацаанд нь барагдуулах.

Шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгах, засах арга хэмжээг газар дээр нь шуурхай авах, цаашид ажил сайжруулах арга хэмжээг нарийн үндэслэлтэй боловруулж, шаардлагатай асуудлыг холбогдох яамд, байгууллага, сангийн яамны улсын санхүүгийн хянан байцаах газар мэдээлэх, шалгалтын дүнг хот, районы гүйцэтгэх захиргаа, АХШХ-ны хуралд оруулж шийдвэрлүүлж байх.

Гурав. Санхүүгийн хянан байцаах тасгийн эрх.

7. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хянан байцаах тасгийн байцаагчид дараах эрх эдлэнэ. Үүнд:

а/Шалгагдаж байгаа газар байгууллага, албан тушаалтнаас мөнгөн хөрөнгө, эд материалын үнэ бүхий зүйлийн баримт, нягтлан бодох бүртгэлийн данс, тайлан баланс, мэдээ судалгаа, төлөвлөгөө, төсөв болон тэдгээрийн холбогдолтой материалыг гаргуулан авч үзэх шаардлагатай гэж үзвэл гардан хүлээж авах.

б/Хяналт шалгалтанд шаардагдах мэдээ материал, тайлбар тодорхойлолтыг холбогдох албан тушаалтнаас бичгээр гаргуулан авах.

в/Шалгалт хийхэд зайлшгүй шаардагдах мэргэжлийн хүмүүсийг удирдаж байгаа хүмүүстэй нь харилцан түр хугацаа-нагаар авч ажиллуулах.

г/Шалгагдаж байгаа газар байгууллагын холбогдох албан тушаалын хүмүүсийг ажлын ба ажлын бус цагаар шалгалтанд шаардагдах асуудлаар дуудан ирүүлж эрхэлсэн ажлыг нь шалгах, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг нь арилгуулах талаар үүрэг даалгавар өгөх.

д/Улс нийгмийн өмч хөрөнгийг идэж ашигласан, үрэгдүүлсэн буюу ажиллагааны муугаар улсад хохирол учруулсан гэм буруутай хүмүүст уг учруулсан хохирлын хэмжээгээр төлбөр оногдуулах, хуулийн байгууллагад шилжүүлэх, эрхэлсэн албан тушаалаас нь өөрчлөх тухай ажлын ба удирдах газарт нь шаардлага тавьж, шалгалтын дүнгийн тухай хэвлэл нийтлүүлэх.

е/Шалгагдаж байгаа байгууллагаас тус улсын хууль тогтоомжийг зөрчиж гаргасан гэрээ хэлэлцээр, тушаал захирамж, заавар, албан тоотыг хэрэгжүүлэх явдлыг түр зогсоож дахин хянаж үзэхийг шаардах.

ж/Шалгалтын дүнг уул байгууллагын хариуцлагатны ба ажилчин албан хаагчдын хурал, зөвлөлгөөн болон яам, тусгай газрын коллеги, хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны хуралд оруулан хэлэлцүүлэх ба шалгалтаар илэрэн зөрчил дутагдлыг нэн даруй засах шаардлага тавьж хариу авах.

з/Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг засч ажил сайжруулаагүй, акт шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд яам тусгай газар, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, АХШХ-ны тушаал, захирамж, тогтоол гаргуулж тус улсын хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах торгууль оногдуулна.

Дөрөв.Хяналт шалгалтын үр дүнг шийдвэрлэх журам.

8.Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хянан байцаах тасгийн байцаагчид шалгалт хийх тухай бүрдээ акт/материал, зааварчлага/ тогтооно.

6.

Актанд шалгасан байцаагч, шалгагдсан газар, байгууллагын дарга, ерөнхий ахлах нягтлан бодогч, холбогдох хүмүүс гарын үсэг зурсан байна.

Холбогдох хүмүүсээс актыг зөвшөөрч гарын үсэг зурахыг татгалзвал акт зөвшөөрөхгүй бамгаа шалтгаан, өөрийн санал, тайлбарыг тодорхой бичиж хавсаргахын хамт актанд гарын үсэг зурна.

9. Акт нь хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргаандаас баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Мөн хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны зөвшөөрлөөр хот районы санхүүгийн хэлтсийн дарга батлаж болно.

10. Хот, районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны хянан байцаах тасаг нь акт, шийдвэрийн биелэлтэнд байнга хяналт тавьж байх ба шалгагдсан газар байгууллагууд акт, шийдвэрийг тогтоосон хугацаанд нь биелүүлж хариу мэдэгдэж байна.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ

З А Х И Р Г А А